

НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ЗАР

2023.05.30

Алтай хот

Дараах эд хөрөнгөнүүдийг Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах орон тооны бус зөвлөлийн 2023 оны 05 сарын 19-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тул иргэд, хуулийн этгээд та бүхнийг нээлттэй дуудлагын худалдаанд өргөнөөр оролцохыг урьж байна.

Үүнд:

д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Тоо ширхэг	Чанар байдал	Дуудах доод үнэ /төгрөг/
1	Doosan-55 маркийн бага оврын экскаватор	1	Хуучин хэрэглэж байсан	4.050.000
2	Doosan-55 маркийн бага оврын экскаватор	1	Хуучин хэрэглэж байсан	4.185.000
3	Хьюндэй бага оврын экскаватор	1	Хуучин хэрэглэж байсан	4.185.000

ДУУДЛАГЫН ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ: Үүнд:

- Иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан байна/.
- Дуудлагын худалдаанд орох хүсэлт /Батлагдсан маягтыг бөглөх/
- Дэнчин тухайн хөрөнгийн дуудах доод үнийн 25% байх бөгөөд дэнчинг байгууллагын "Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын нэмэлт санхүүжилтийн 100050051424" тоот дансанд тушааж, баримтыг материалд хавсаргана.

Дуудлагын худалдаанд оролцох иргэд, хуулийн этгээд дээрх бичиг баримтыг бүрдүүлэн дугтуйд хийж битүүмжлээд, дугтуйны гадна талд худалдан авах хөрөнгийн нэр, төрлийг бичсэн байна.

ДУУДЛАГЫН ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ХҮСЭЛТ ГАРГАХ:

Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтээ аймгийн Нутгийн удирдлагын ордонд байрлах Орон нутгийн өмчийн газрын 105 тоот өрөөнд байрлуулсан лацтай хайрцагт зар гарсан өдрөөс эхлэн 2023 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 18:00 цагаас өмнө хийсэн байна.

Дуудлагын худалдааг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 10:00 цагт Говь-Алтай аймгийн Нутгийн удирдлагын ордны хурлын танхимд зохион байгуулна.

Худалдан авах хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, дуудлага худалдаанд оролцох хүсэлтийн маягтыг Орон нутгийн өмчийн газрын 105 тоот өрөөнөөс авна уу.

АНХААРАХ ЗҮЙЛС:

- Нээлттэй дуудлагын худалдаанд зарлагдсан хөрөнгийг дуудлага худалдаанд оролцох иргэд, хуулийн этгээд хөрөнгийг өөрийн биеэр сайтар үзэж танилцан, сонголтоо хийнэ үү.
- Дуудлагын худалдаа зарласан цагтаа эхлэх тул оролцогч иргэд, хуулийн этгээд та бүхэн хугацаа хоцрохгүй байхыг анхааруулж байна.

Жич: Төрийн сангийн гүйлгээ цахимаар хийгдэж байгаа тул дэнчингийн мөнгийг буцааж авах иргэд Татварын удирдлагын нэгдсэн системд харилцах дансаа заавал бүртгүүлсэн байх шаардлагатай. Гүйлгээг ажлын 3 хоногт багтаан хийгдэнэ.

ЛАВЛАХ УТАС: 70483302

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР